



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/319

Өмнөдэлгэр сум

Засаг даргын нөөц сангаас
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол үндэсний өв соёлыг сурталчлан таниулах, уламжлалт ёс заншлыг хойч үедээ өвлүүлэх, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол бахархлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах 2,600,000 (хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.



Р.ЭНХТӨР

2325310533

D:\disk\bichig hereg/zahiramj